



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/251

Чингис хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дугаар зүйлийн 40.2.2, 40.2.4, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 2-р багийн иргэн Л.Дугарын өргөдлийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгчээр ажиллаж байсан Г.Энхжаргалын буяны ажилд зориулан 500000 /таван зуун мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын шагнал урамшуулал, буцалтгүй тэтгэмжийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА